

Юнгманнова 6 гудамжинд байрлах Ихлава хотын
дунд сургуулийн тэтгэмжийн байгууллага

2019 оны 9 сарын 3-аас эхлэн Суралцагчдад үйлчилж сургууль хүрэх автобусны хуваарь:

7:20 минут - Horní Kosov (автобусны зогсоол) -- Lírová гудамжнаас явах

- Rantířovská
- U Hřbitova-Dům zdraví . U Cvičiště D,F шугмын зогсоол дээр
- Na Hliništi зогсоол
- 17 Listopadu
- Tolstého болон Sokolovna зогсоол
- Legionářů гудамжны Fritzova зогсоол
- Chlumova
- Masarykova (хотын төвийн дээд зогсоол)
- Masarykova (төвийн доод зогсоол буюу Тролебусны)
- E эргэлтээр эргэж Chlumova зогсоолд очно
- Gorkého
- тойроогоор эргээд Gorkého зогсоол
- Kaufland
- Královský vršek
- 5.května зогсоол
- Zrzavého -- Jungmannova сургууль руу

*Сургуулийн сурагч бүрт зогсож үйлчилнэ.

*Гэр бүлийн хэлбэрийн сургууль

Сургуулийн захиралтай тохиролцсоны дагуу тухайн хүүхэдтэй ганцаарчлан ажиллах
боломжтой тул Та тодорхой мэдээлэл авахыг хүсвэл: www.jungzs.cz

Таны асуултанд хариу өгөх утас: 567 564 441 эсвэл эмайл: ivana.malkova@jungzs.cz

Бэлтгэл ангийн үндсэн зорилго юу вэ?

Тус сургууль нь хотын хөдөлгөөн багатай хэсэгт байрлах ба эцэг эхийн санал хүсэлтийн дагуу хүүхдийг сургууль хамт олны хүрээлэлд, боловсролын үйл ажиллагаанд хүндрэлгүйгээр бүрэн оролцуулан, хүүхдийг сургуульд амжилттай суралцах анхны боломжийг нээж өгнө.

Бэлтгэл ангид бид гадаад хүүхдүүдийг сурахад туслана.

Бэлтгэл анги юу хийдэг вэ?

-Хичээл сургалт нь өдөр бүр хичээлийн 4 цагаар буюу өглөө 8.00-11.40 цаг хүртэл явагдана. 7 хоногт 1удаа 5цагийн хичээл (өөрөөр хэлбэл 12.35 мин хүртэл) орно.

-Хүүхдүүд сургууль дээрээ өдрийн хоолонд орох бөгөөд эцэг эхийн зөвшөөрлийн дагуу өглөө 6.30-15.30цаг хүртэл сургуулийн клуб-д үлдэх боломжтой.

-Бэлтгэл анги нь үнэ төлбөргүй ба энэ сургалт нь таны сайн дурын хүсэлтээр явагдана.

-Энэ сургалтын давуу тал нь: Цөөн тоотой ангийн хүүхдүүдтэй багш хүүхэд бүртэй нэг бүрчлэн ажиллах боломжтой байдаг.

-Хүүхдүүд компьютерийн өрөө, биеийн тамирын заал болон амралтын, тоглоомын өрөө, сургуулийн гадаа талбай, сургуулийн номын санг ашиглах ба бусад мэдээллийг авах боломжтой.

-Соёлын болон спортын арга хэмжээ, бусад аялалд оролцох боломжтой.

-Эцэг эхийн хүсэлтээр хүүхдүүд багш ба туслах багшийн оролцоотойгоор автобусаар хотын төв хүртэл хамт зорчих боломжтой.

Сургалт хүмүүжлийн боловсролын агуулга юу вэ?

-Нийгэм, Соёлын болон эрүүл ахуйн зөв дадалд сургах

-Оюуны боловсролд туслах "хэл яриа, харилцааны мэдэгдхүүнд сургах, математикийн мэдлэг, танин мэдэхүйн болловсрол гэх мэт..."

-Хөгжмийн боловсрол

-Урлан бүтээх ахуйн сургалт

-Хөдөлмөрийн хичээлийн мэдлэг

-Биеийн тамир, спортын сургалт хүүхдүүдэд зааж сургана.

Хэрэв энэхүү бэлтгэл бүлгийн сургалтын талаарх мэдээллийг дэлгэрэнгүй авахыг хүсвэл Та доорх хаягаар холбогдоорой.

Základní škola Jihlava, Jungmannova 6, příspěvková organizace

Tel: 567 564 441, 567 564 440 эсвэл 731 698 908

www.jungzs.cz